

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/112/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70273204 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Товчилсон үгийн жагсаалт	3
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
Асуудлыг онцолсон хэсэг	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Төлбөрийн акт	Error! Bookmark not defined.
5.2 Албан шаардлага.....	Error! Bookmark not defined.
5.3 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 4/60.
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд өөрийн орлогыг давуулан биелүүлсэн ба үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд орхигдуулсан асуудал гараагүй болно. Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Тус байгууллага нь Газар, зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас газрын нэгдсэн систем буюу www.egazar.gov.mn цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэн олон нийтэд хүргэж байна.

Аудитын гол асуудал

Арилжааны банкны данс болон касст орлого авсан 80.0 мянган төгрөгийн гүйлгээг бүртгээгүй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 330,166.2 мянган төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон

G/Архив/Албан бичиг 2024/ А4

219020179

хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,650,122.0	231,119,497.9
33	АВЛАГА	879,935.0	220,988,559.9
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	879,935.0	297,769.1
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.0	220,690,790.8
35	БАРАА МАТЕРИАЛ	11,770,187.0	10,130,938.0
354	Хангамжийн материал	11,770,187.0	10,130,938.0
35410	Бичиг хэргийн материал	1,557,500.0	3,182,900.0
35420	Аж ахуйн материал	4,550,158.0	1,442,908.0
35470	Бусад хангамжийн материал	5,662,529.0	5,505,130.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	533,772,788.3	554,200,714.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	533,772,788.3	554,200,714.8
392	Биет хөрөнгө	509,647,788.3	528,722,714.8
39201	Барилга, байгууламж, орон сууц	188,640,500.0	246,511,352.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	-25,390,957.3	-32,287,071.6
39203	Авто-тээврийн хэрэгсэл	159,715,500.0	159,715,500.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-122,120,500.0	-136,380,499.9
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	542,532,439.2	594,099,291.4
39206	Хуримтлагдсан элэгдэл	-248,263,471.8	-326,264,435.2
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,660,784.0	43,779,584.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,126,505.8	-24,961,865.8
39209	Зам, гүүрийн байгууламж	0.0	4,510,860.0
393	Биет бус хөрөнгө	24,125,000.0	25,478,000.0
39301	Програм хангамж	1,980,000.0	3,410,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,980,000.0	-2,057,000.0
39303	Бусад биет бус хөрөнгө	24,125,000.0	24,125,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	546,422,910.3	785,320,212.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	450.0	59,167.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	450.0	59,167.7
413	Өглөг	450.0	59,167.7
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.0	59,167.7
4136	Бусад өглөг	450.0	0.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	450.0	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	546,422,460.3	785,261,045.1
51	Засгийн газрын хувь оролцоо	546,422,460.3	785,261,045.1
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	345,023,143.4	345,023,143.4
51101	Өмч: - төрийн	345,023,143.4	345,023,143.4
512	Хуримтлагдсан үр дүн	102,190,097.3	341,028,682.1
51210	Өмнөх үеийн үр дүн	102,190,097.3	102,190,097.3
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	238,838,584.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	99,209,219.5	99,209,219.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	546,422,910.3	785,320,212.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,116,134,101.0	1,833,799,019.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,236,109.0	250,075,119.1
120	Нийтлэг татварын бус орлого	24,236,109.0	250,075,119.1
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,236,109.0	250,075,119.1
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,560,764.0	249,335,166.8
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,675,345.0	739,952.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,091,897,992.0	1,583,723,900.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	662,965,300.0	1,215,895,300.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	662,965,300.0	1,215,895,300.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	428,597,892.0	307,322,674.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.0	500,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	425,597,892.0	306,822,674.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.0	58,066,926.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.0	58,066,926.0
1330	Төсвийн захирагчдаас	334,800.0	2,439,000.0
133003	Хөрөнгийн	334,800.0	2,439,000.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,052,894,027.9	1,594,960,434.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,052,894,027.9	1,594,960,434.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	890,540,430.5	1,539,711,938.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	499,492,330.6	1,024,692,314.2
210101	Үндсэн цалин	396,290,262.0	614,588,651.6
210102	Нэмэгдэл	90,854,088.6	334,873,987.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	25,030,000.0
210104	Урамшуулал	12,347,980.0	50,199,675.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,762,481.0	131,880,262.7
210201	Тэтгэврийн даатгал	43,812,423.8	89,851,373.4
210202	Тэтгэмжийн даатгал	5,086,179.9	10,323,923.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,971,503.9	9,161,735.1
210204	Ажилгүйдлийн даатгал	990,214.6	2,049,384.6
210205	Эрүүл мэндийн даатгал	9,902,158.9	20,493,846.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,193,484.0	24,845,822.5
210301	Гэрэл, цахилгаан	2,292,570.0	3,121,186.5
210302	Түлш, халаалт	17,039,719.0	19,535,863.6
210303	Цэвэр, бохир ус	1,861,195.0	2,188,772.5
2104	Хангамж, бараа материалын зардал	207,231,259.2	163,302,266.0
210401	Бичиг хэрэг	77,892,482.0	48,468,893.0
210402	Тээвэр, шатахуун	61,430,540.0	66,635,394.0

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	602,260.0	638,670.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	67,305,977.2	47,559,309.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.0	99,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.0	99,000.0
2107	Томилолт, зочны зардал	7,897,500.0	3,992,500.0
210702	Дотоод албан томилолт	7,897,500.0	3,992,500.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,022,700.0	44,615,581.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,878,500.0	44,544,881.0
210803	Даатгалын үйлчилгээ	144,200.0	70,700.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,940,675.7	146,284,191.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,088,601.0	45,214,754.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,852,074.7	101,069,437.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	162,353,597.4	55,248,496.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,263,600.0	2,440,000.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,038,000.0	2,440,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,225,600.0	0.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,763,887.4	47,752,395.2
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.0	27,089,110.4
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,763,887.4	17,659,976.0
213304	Хөрөнгийн	0.0	3,003,308.8
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	104,242,813.0	0.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	104,242,813.0	0.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,083,297.0	5,056,101.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,072,186.0	5,056,101.0
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	6,011,111.0	0.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	63,240,073.1	238,838,584.8
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	63,240,073.1	238,838,584.8

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,111,123,956.0	1,609,929,276.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,560,764.0	28,644,376.0
120	Нийтлэг татварын бус орлого	19,560,764.0	28,644,376.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,560,764.0	28,644,376.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,560,764.0	28,644,376.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,091,563,192.0	1,581,284,900.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	662,965,300.0	1,215,895,300.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	662,965,300.0	1,215,895,300.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	428,597,892.0	307,322,674.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.0	500,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	425,597,892.0	306,822,674.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.0	58,066,926.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.0	58,066,926.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	945,394,856.0	1,481,319,892.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	945,394,856.0	1,481,319,892.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	783,114,258.6	1,423,877,116.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	501,439,428.6	1,015,573,572.0
210101	Үндсэн цалин	396,973,563.0	570,307,731.3
210102	Нэмэгдэл	92,117,885.6	376,841,479.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	22,358,000.0
210104	Урамшуулал	12,347,980.0	46,066,361.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,712,200.0	130,006,225.1
210201	Тэтгэврийн даатгал	42,048,027.1	92,320,886.7
210202	Тэтгэмжийн даатгал	4,415,716.5	9,195,153.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,532,333.2	7,724,652.1
210204	Ажилгүйдлийн даатгал	883,183.3	2,097,501.9
210205	Эрүүл мэндийн даатгал	8,832,939.9	18,668,030.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,193,484.0	24,225,100.0
210301	Гэрэл, цахилгаан	2,292,570.0	2,949,586.5
210302	Түлш, халаалт	17,039,719.0	19,535,863.6
210303	Цэвэр, бохир ус	1,861,195.0	1,739,650.0
2104	Хангамж, бараа материалын зардал	13,335,940.0	5,728,488.0
210401	Бичиг хэрэг	3,880,640.0	1,412,858.0
210402	Тээвэр, шатахуун	8,136,600.0	2,992,300.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	357,100.0	550,070.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	961,600.0	773,260.0
2105	Нормативт зардал	288,400.0	112,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	288,400.0	112,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	549,600.0	6,851,838.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.0	1,256,200.0

210604	Урсгал засвар	549,600.0	5,595,638.0
2107	Томилолт, зочны зардал	8,330,000.0	4,568,500.0
210702	Дотоод албан томилолт	8,330,000.0	3,992,500.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.0	576,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	102,596,539.0	95,458,823.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	102,452,339.0	95,229,073.5
210803	Даатгалын үйлчилгээ	144,200.0	70,700.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.0	159,050.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,668,667.0	141,352,570.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,668,667.0	141,352,570.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	162,280,597.4	57,442,776.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,190,600.0	4,634,280.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,965,000.0	4,634,280.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,225,600.0	0.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,763,887.4	47,752,395.2
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.0	27,089,110.4
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,763,887.4	17,659,976.0
213304	Хөрөнгийн	0.0	3,003,308.8
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	104,242,813.0	0.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	104,242,813.0	0.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,083,297.0	5,056,101.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,072,186.0	5,056,101.0
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	6,011,111.0	0.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	165,729,100.0	128,609,383.3
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	165,729,100.0	120,757,412.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	165,729,100.0	120,757,412.0
2200	Дотоод эх үүсвэрээр	165,729,100.0	120,757,412.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	165,729,100.0	120,757,412.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-165,729,100.0	-120,757,412.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.0	7,851,971.3
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,023,143.4	99,209,219.5	(94,005,454.1)	350,226,908.8
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	345,023,143.4	99,209,219.5	(94,005,454.1)	350,226,908.8
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	10,684,957.6	10,684,957.6
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,023,143.4	99,209,219.5	102,190,097.3	546,422,460.3
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,023,143.4	99,209,219.5	102,190,097.3	546,422,460.3
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	345,023,143.4	99,209,219.5	102,190,097.3	546,422,460.3
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	238,838,584.8	238,838,584.8
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,023,143.4	99,209,219.5	341,028,682.1	785,261,045.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	625,220,100.0	1,202,559,026.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	625,220,100.0	1,202,559,026.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	625,220,100.0	1,198,674,746.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	467,681,800.0	966,577,916.4
210101	Үндсэн цалин	264,832,600.0	570,307,731.3
210102	Нэмэгдэл	190,568,400.0	327,845,823.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,280,800.0	22,358,000.0
210104	Урамшуулал	0.0	46,066,361.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,909,000.0	122,666,887.4
210201	Тэтгэврийн даатгал	40,057,800.0	87,000,317.4
210202	Тэтгэмжийн даатгал	4,713,000.0	8,694,543.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,770,200.0	7,307,835.1
210204	Ажилгүйдлийн даатгал	942,700.0	1,812,096.8
210205	Эрүүл мэндийн даатгал	9,425,300.0	17,852,094.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,737,900.0	24,225,100.0
210301	Гэрэл, цахилгаан	905,800.0	2,949,586.5
210302	Түлш, халаалт	12,500,000.0	19,535,863.6
210303	Цэвэр, бохир ус	1,332,100.0	1,739,650.0
2104	Хангамж, бараа материалын зардал	3,894,400.0	5,728,488.0
210401	Бичиг хэрэг	804,800.0	1,412,858.0
210402	Тээвэр, шатахуун	2,658,400.0	2,992,300.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	116,800.0	550,070.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	314,400.0	773,260.0
2105	Нормативт зардал	141,300.0	112,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	141,300.0	112,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,413,400.0	26,985,500.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,144,000.0	1,716,100.0
210604	Урсгал засвар	25,269,400.0	25,269,400.0
2107	Томилолт, зочны зардал	2,724,800.0	3,992,500.0
210702	Дотоод албан томилолт	2,724,800.0	3,992,500.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,594,100.0	21,496,674.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,510,000.0	21,381,974.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	13,400.0	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	70,700.0	70,700.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.0	44,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,123,400.0	26,889,680.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,123,400.0	26,889,680.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.0	3,884,280.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.0	3,884,280.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.0	3,884,280.0
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	594,930,100.0	1,332,761,237.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	594,930,100.0	1,215,895,300.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	594,930,100.0	1,215,895,300.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.0	28,060,206.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	28,060,206.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	313,832,546.00	218,016,943.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	313,832,546.00	218,016,943.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	310,832,546.00	218,016,943.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	48,995,655.53
210102	Нэмэгдэл	0.00	48,995,655.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	7,339,337.72
210201	Тэтгэврийн даатгал	0.00	5,320,569.31
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	500,609.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	416,817.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	285,405.16
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	815,936.51
2107	Томилот, зочны зардал	0.00	576,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	576,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	258,182,039.00	135,391,755.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	258,182,039.00	135,391,755.75
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	115,050.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,233,067.00	24,964,194.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,233,067.00	24,964,194.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,000,000.00	750,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	750,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,000,000.00	750,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	384,597,892.00	278,183,989.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	384,597,892.00	278,183,989.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	381,597,892.00	218,016,943.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн ГХБХБГ нь газрын харилцаа, барилгын багц хуулиудыг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулж, газрын шинэтгэлийг бодлогыг эрчимжүүлж, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хот байгуулалт хот төлөвлөлтийн үйл ажиллагааг орчин үеийн мэдээллийн технологид түшиглэн иргэдийн амьжиргааны түвшнийг сайжруулахад чиглэсэн үйлчилгээг нээлттэй шуурхай үзүүлэх чиг үүрэг бүхий Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын харьяа байгууллага юм.

2023 оныг “Газар, байгаль, эдийн засаг, нийгмийн нөөц, чадавхад тулгуурлан газар ашиглалт, хамгаалалтын үр ашгийг дээшлүүлэх, газрыг эдийн засгийн хувьд үндэслэл сайтай, үр ашигтай, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан газар зохион байгуулалтыг хөгжүүлнэ” зорилго дэвшүүлэн 4 зорилт, 127 ажил, арга хэмжээг төлөвлөн ажилласан байна. Дэвшүүлсэн зорилго, зорилт, арга хэмжээг 98,9 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн ГХБХБГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах,
- Нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох
- Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйл “Нэгжийн эдийн засгийн үндсийг бүрдүүлэх төр орон нутгийн удирдлага”, 20 дугаар зүйл “Орон нутгийн чиг үүрэг”, Газрын тухай хуулийн 8 дугаар зүйл “Хилийн цэс, газар усны нэр, газар усны нэрийн болон газрын сангийн зураг”, 12 дугаар зүйл “Хот, тосгон, бусад суурин, нийслэл хотын эдэлбэр газар”, мөн Төсвийн тухай хуулийн зарим зүйл заалт тухайлбал 8 дугаар зүйл “Төсвийн цагалбар”, 23 дугаар зүйл “Төсвийн орлого”, 24 дүгээр зүйл “Төсвийн зарлага”, 27 дугаар зүйл “Төсвийн төсөлд тавигдах шаардлага”-д өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Тус байгууллагын дотоод хяналтыг барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн нь хариуцан гүйцэтгэдэг бөгөөд байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагаанд хяналт хийгдээгүй байна.

Төв аймгийн ГХБХБГ нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, аудитын алба, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын хяналт, шинжилгээ, дотоод аудитын хэлтэс хариуцан гүйцэтгэж байна. 2023 онд тус байгууллагын үйл ажиллагаанд Санхүү хяналт, аудитын албанаас аудит хийгээгүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино. Төв аймгийн ГХБХБГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2012 оны "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөн ажиллаж байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн ГХБХБГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 238,897.3 мянган төгрөгөөр буюу 43,7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	879.9	220,988.6	220,108.6
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	11,770.2	10,130.9	(1,639.2)
Үндсэн хөрөнгө	533,772.8	554,200.7	20,427.9
Нийт хөрөнгө	546,422.9	785,320.2	238,897.3
Өр төлбөр	0.5	59.2	58.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	546,422.5	785,261.0	238,838.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	546,422.9	785,320.2	238,897.3

Авлага данс оны эхнээс 220,108.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь барилга хөгжлийн төвөөс авах барилга, техник хяналтын зардлын авлага байгаа бөгөөд тооцоо нийлж баталгаажсан байна.

Бараа материал дансны хувьд бичиг хэргийн материал 1,625.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, аж ахуйн материал 3,107.3 мянган төгрөг, бусад хангамжийн материал 157.4 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 57,871.0 мянган төгрөгийн барилга байгууламж, орон сууц, 50,827.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 6,119.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 4,511.0 мянган төгрөгийн зам гүүрийн байгууламж, 1,430.0

мянган төгрөгийн программ хангамж худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 740.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,615,895.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 58,066.9 мянган төгрөг, нийт зарлагыг 1,673,962.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас үндсэн үйл ажиллагааны зардлыг 1,215,895.3 мянган төгрөг болгон бууруулан баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр улс, орон нутгийн төсвөөс 1,215,895.3 мянган төгрөгийг санхүүжихээр баталсан байна. Төсвийн тодотголоор 94,970.0 мянган төгрөгөөр төсвийг нэмэгдүүлж, 1,310,895.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,250,760.5 мянган төгрөг буюу 95,4 хувьтай байгаа нь техник хяналтын зардлыг 60,135.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Газрын зураглал, кадастр -Үндсэн үйл ажиллагааны зардал	1,179,362.20	1,179,362.20	-	100.0
2	Газрын зураглал, кадастр -Байр ашиглалтын үйлчилгээ	8,502.00	8,502.00	-	100.0
3	Газрын зураглал, кадастр -Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	28,031.10	28,031.10	-	100.0
4	Газрын зураглал, кадастр -Барилгын техник хяналт	95,000.00	34,864.75	60,135.25	36.7
	Дүн	1,310,895.30	1,250,760.05	60,135.25	95.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар нь 2023 онд нэмэлт санхүүжилтийн дансанд албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл 58,066.9 мянган төгрөг

болон үндсэн үйл ажиллагааны санхүүжилт 218,016.9 мянган төгрөг, дээд шатны байгууллагаас 500.0 мянган төгрөг, бусад орлого 584.1 мянган төгрөг, нийт 277,168.0 мянган төгрөгийн орлого орж 56,334.9 мянган төгрөгийг албан хаагчдад, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд 85,990.7 мянган төгрөгийг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулалд 750.0 мянган төгрөгийг, бараа материалын зардал 312.0 мянган төгрөг, хэвлэл мэдээллийн эх бэлтгэх зардалд 115.0 мянган төгрөгийг барилгын техник хяналт хийхэд шаардлагатай тоног төхөөрөмж материал худалдан авахад 15,673.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 8,978.7 мянган төгрөгийг зарцуулж, 3,003.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71504 /Газрын зураглал, кадастр /-80101 /Үндсэн үйл ажиллагааны зардал	2023.01.01 2023.12.31	Газрын кадастрыг эрхэлж, аймгийн газрын мэдээллийн сан байгуулж, олон нийтэд мэдээллээр үйлчлэх	Газрын мэдээллийн санг зохих журмын дагуу гаргаж сум, аймгийн Засаг даргад тайлагнасан.	1,179,362.20	1,179,362.20
2	71504 /Газрын зураглал, кадастр /-80226 /Байр ашиглалтын үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Газрын зураглал, кадастр - Байр ашиглалтын үйлчилгээ	байгууллагын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай байр ашиглалттай холбоотой зардлыг гаргасан	8,502.00	8,502.00
3	71504 /Газрын зураглал, кадастр /-80802 /Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2023.01.01 2023.12.31	Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж болон хөдөлмөрийн дотоод журамд заасан нөхцөлд олгох тэтгэмж урамшуулал	Албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлтийг олгож, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийг татан төвлөрүүлсэн	28,031.10	28,031.10
4	71504 /Газрын зураглал, кадастр /-82404 /Барилгын техник хяналт	2023.01.01 2023.12.31	Улс, аймгийн хөрөнгө оруулалт болон төсөл, хөтөлбөрийн шугамаар хийгдэж байгаа хөрөнгө оруулалт их засварын ажилд захиалагчийн үүрэг гүйцэтгэж аймгийн хэмжээнд баригдаж байгаа орон сууц, үйлдвэр үйлчилгээний барилгыг төлөвлөгөөтэй өнгө үзэмжтэй, чанартай, стандартын шаардлагад нийцсэн байдлыг хангуулж ажиллах	Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажилд хяналт тавьж ажилласан байна.	95,000.00	34,864.75
	Дүн				1,310,895.30	1,250,760.05

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 1 хөтөлбөр, арга хэмжээг 97,9 хувьтай хийж гүйцэтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн ГХБХБГ-ын 2023 онд төсвийн хөрөнгөөр БСБ компьютерс ХХК-иас 32,818.4 мянган төгрөг, Бараат төгс конкрет ХХК-иас 19,560.0 мянган төгрөг, БСБ оффис мебель ХХК-иас 2,096.8 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, тавилга худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн ГХБХБГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах төрийн хэмнэлтийн тухай хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн ГХБХБГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн №01/05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,116,134.1 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 16,742.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 11,719.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.3.2-т төсвийн зардлыг бууруулж, хэмнэлт гаргаж ажиллах, бараа материалын болон үйлчилгээний орлогод хяналт тавьж орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах бараа материалын болон үндсэн хөрөнгийн ашиглалт хамгаалалтад хяналт тавих тухай тусгасан байна. Үндсэн үйл ажиллагааны батлагдсан төсвөөс цалингийн зардал 15,733.4 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 24,146.8 мянган төгрөг, барилгын техник, хяналтын зардал 60,135.2 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн зардлын эх үүсвэрээс 3,003.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Төрийн хэмнэлтийн тухай хууль заасан арга хэмжээнд зардал гаргаагүй ба байгууллагын бүртгэлтэй автотээврийн хэрэгслийн улсын дугаарыг ялгах дэвсгэр бүхий дугаараар сольсон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн ГХБХБГ-ын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд байршуулах мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

2023 онд тус байгууллагын үйл ажиллагаанд завсрын аудит хийсэн бөгөөд 2023 оны эхний 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагааг хамруулж нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 154,251.0 мянган төгрөгийн бичилтийг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Төв аймгийн ГХБХБГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 180.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 200,453.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 589,324.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн байна. Зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг 2023 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн №07/377 дугаарын албан бичгээр ирүүлсэн байна. 2023 оноос эхлэн төрийн сангийн программ нь гүйлгээг нэхэмжлэх эхэлж үүссэний дараа хийдэг болсон нь цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй зөрчил буурах үндэс болсон байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	3	355,113.8	3	355,113.8	100
Нийт дүн	3	355,113.8	3	355,113.8	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Техник, хяналтын зардал, бараа материалын бүртгэл, түүнд тавих хяналтын талаар авч үзэхээр шийдвэрлэсэн.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 80.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 80.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- ХААН банкны 5721505031 дугаарын данс болон кассын орлого авсан 80.0 мянган төгрөгийн гүйлгээг бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 332,810.4 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 332,810.4 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Зөвлөмж

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

Харилцагч байгууллага, иргэнтэй хийсэн худалдан авалтыг төлбөрийн цахим баримт, нэхэмжлэхийн дүнтэй тулгалт хийхэд 613.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Сангийн сайдын 347 дугаар тушаалын “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 5-д “Төлбөрийн баримт” заалтыг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил үйлчилгээ бүрийг цахим баримтаар баталгаажуулах

2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилт

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 330,166.2 мянган төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7-д “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тухай заалтыг болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг цаашид ашиглах боломжтой бол дахин үнэлэх, боломжгүй бол эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.

3. Төсвийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой

Бараа ажил үйлчилгээний зардлаас 2,031.1 мянган төгрөгийн гэрээт ажилчдын цалин олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 90 дүгээр тушаал “Эдийн засгийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

ангилал ашиглах заавар”, санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эдийн засгийн ангиллын дагуу зардлыг төлөвлөж, тайлагнаж байх
Аудитаар өгсөн зөвлөмжийн хариуг 2024 оны 6 дугаар сарын 30-ны дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн сангийн харилцах данснаа арилжааны банкаар дансаар дамжуулан касст орлого авсан мөнгөн гүйлгээг бүртгээгүй	1	80.0	1	80.0			1	80.00
Дүн	1	80.0	1	80.0			1	80.00

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
Харилцагч байгууллага, иргэнтэй хийсэн худалдан авалтыг төлбөрийн цахим баримт, нэхэмжлэхийн дүнтэй тулгалт хийхэд зөрүүтэй байна	1	613.2					1	613.2		
Бараа ажил үйлчилгээний зардлаас гэрээт ажилчдын цалин олгож, НДШ төлсөн байна	1	2,031.1					1	2,031.1		
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 330,166.2 мянган төгрөгийн өртгөтэй 1176 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.	1	330,166.2					1	330,166.2		
Дүн	3	332,810.4					3	332,810.4		